

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГААНЫ ОНЦГОЙ БҮС  
ХОНГКОНГД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН “НИСЭХИЙН ЦАГ УУРЫН ҮЙЛЧИЛГЭЭ,  
НИСЛЭГ ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА (МЕТ-АТМ)”  
СЭДЭВТ СУРГАЛТ СЕМИНАРТ ХАМРАГДСАН ТУХАЙ ТАЙЛАН

Улаанбаатар хот

2018 оны 10-р сарын 15-ны өдөр

БНХАУ-ын засаг, захиргааны онцгой бүс Хонгконгд Дэлхийн цаг уурын байгууллага, Хонгконгийн нисэхийн цаг уурын байгууллагын санхүүжилтээр Дэлхийн цаг уурын байгууллагын гишүүн орнуудын цаг уурын болон нислэг хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын албан хаагчдад зориулсан “Нисэхийн цаг уурын үйлчилгээ, нислэг хөдөлгөөний үйлчилгээний хамтын ажиллагаа (МЕТ-АТМ)” сэдэвт сургалт, семинарт НЦУТ-ийн ахлах синоптик инженер Н.Энхдалай 2018 оны 10 дугаар сарын 08-11-ний өдрүүдэд амжилттай хамрагдлаа.

Энэхүү сургалт семинарыг ДЦУБ-ын мэргэжилтэнгүүд, Япон, Франц, Хонгконгийн цаг уурын байгууллагын сургалт, хөгжил хариуцсан мэргэжилтэн, сургагч багш нар удирдан явуулсан. Сургалтанд ашиглагдсан бүх материал, мэдээ мэдээллийг цаасан болон электрон хэлбэрээр хадгалсан.

Тус сургалтанд 18 орны нийт 22 оролцогчид хамрагдсан. Үүнд: Оросын Холбооны улсаас-2, Мьянмар улсаас -1, Тайланд улсаас -1, Малайз улсаас-2, Монгол улсаас -2, Египет улсаас-1, Узбекистан улсаас-1, Бүгд найрамдах Конго улсаас-1, Нигери улсаас-1, Өмнөд Африк улсаас-2, Өмнөд Судан улсаас-1, Энэтхэг улсаас-1, Австрали улсаас-1, АНУ улсаас-1, Франц улсаас-1, Япон улсаас-1, Балба улсаас-1, Гондурас улсаас- 1 оролцогч тус тус оролцсон.

БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс Хонгконгийн “Нисэхийн цаг уурын үйлчилгээ, нислэг хөдөлгөөний үйлчилгээний хамтын ажиллагаа (МЕТ-АТМ)” сэдэвт сургалт семинар БНХАУ-ын “Хонгконг ажиглалтын төв”-ийн сургалтын төвд зохион байгуулагдсан. “Нисэхийн цаг уурын үйлчилгээ, нислэг хөдөлгөөний үйлчилгээний хамтын ажиллагаа (МЕТ-АТМ)” сэдэвт сургалт семинарт хамрагдсанаар Бүс нутгийн агаарын навигацийн төлөвлөлт (GANP)-ийн Нисэхийн системийн шинэчлэлт (ASBU)–ийн хүрээн дэх Нислэг хөдөлгөөний үйлчилгээний удирдлагын тогтолцооны (АТМ) шаардлагууд, Цаг уур (МЕТ)-ын үйлчилгээний сайжруулалт-бичил масштаб ба хэт богино хугацааны тоон загварчлалыг судлах, Нислэг хөдөлгөөний үйлчилгээний тогтолцоо, цаг уурын үйлчилгээний хамтын үйл ажиллагаанд (МЕТ-АТМ) хэрэгжүүлж буй хамтарсан төслүүдтэй танилцах, нисэхийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлж буй холбооны мэдээлэл төлөвлөлтийн систем (SWIM)-ийн хүрээн дэх IWXHM–ийн хэрэгжилт, үе шаттай танилцаж өөрийн оронд хэрэгжүүлэх талаар туршлага судлахад сургалт семинарын зорилго оршино.

Сургалтын хугацаанд дараах сэдвүүдийг судалсан. Үүнд:

- Сургалт, семинарын зорилго болон нислэгийн цаг уур ба нислэг хөдөлгөөний үйлчилгээний хамтын ажиллагаа
- БНХАУ-ын Хонгконгын нисэхийн цаг уурын байгууллагатай танилцаж, тус улсын нисэхийн цаг уурын байгууллага, нислэгийн цаг уурын үйлчилгээ, үйл ажиллагаа

- Бүс нутгийн агаарын навигацийн төлөвлөлт (GANP)-ийн Нисэхийн системийн шинэчлэлт (ASBU)-ын хүрээн дэх Нислэг хөдөлгөөний үйлчилгээний удирдлагын тогтолцооны (ATM) шаардлагууд;
- Нисэхийн цаг уурын үйлчилгээг сайжруулах төсөл (AvRDP) - ийн хүрээн дэх Цаг Уур (MET)-ын үйлчилгээний сайжруулалт-бичил масштаб ба хэт богино хугацааны тоон загварчлал;
- Нислэг хөдөлгөөний үйлчилгээний тогтолцоо, цаг уурын үйлчилгээний хамтын үйл ажиллагаанд (MET-ATM) хэрэгжүүлж буй хамтарсан төслүүд;
  - а. Япон улсын Нарита нисэх буудал;
  - б. Австри улсын нисэхийн цаг уурын үйлчилгээ;
- Нисэхийн цаг уурын мэдээний чанарыг дээшлүүлэх, үйлчилгээг сайжруулж буй бусад орны туршлагауд, нисэхийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлж буй холбооны мэдээлэл төлөвлөлтийн систем(SWIM)-ийн хүрээн дэх IWXXM-ийн хэрэгжилтийн үе шат;

Нислэг хөдөлгөөний үйлчилгээний удирдлагын тогтолцоо (ATM) ба Нислэгийн урсгал төлөвлөлтийн үйлчилгээний удирдлагын тогтолцоо (ATFM)-г дэмжих зорилгоор Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын газар болон Цаг уурын байгууллага нь хамтын ажиллагааны хүрээнд аэродромын цаг агаарын хязгаарлалтуудыг тогтоосон байдаг. Цаг уурын үйлчилгээнд ашиглагдах хязгаарлалтуудыг тогтоохдоо хөөрч буух зурвасын үйл ажиллагаанд нөлөөлөхүйц цаг агаарын үзэгдлүүдийн босго утгыг тодорхойлно. Үүнд: хөөрч буух зурвасын гадаргад нөлөөлөх, нисэн ирж буй агаарын хөлгийн зайд нөлөөлөх, хурданд нөлөөлөх, агаарын хөлгийн минимумд нөлөөлөхүйц хөндлөнгийн салхи гэх мэт.

БНХАУ-ын Хонконгийн агаарын навигацийн үйлчилгээг үзүүлэх Нисэх буудлын цаг уурын хязгаарлалтуудыг АБХ, үүлний доод суурийн өндөр, хөндлөнгийн салхи, угтах салхи, шилжлэг салхи, дуу цахилгаан, борооны бөөн үүлний хувьд тогтоосон байна.

ОУИНБ-ын нисэхийн системийн шинэчлэлт (ASBU)-ийн хүрээнд мэдээлэл солилцооны менежментийг цаашид илүү цогц систем болгоход чиглэсэн. Бүс нутгийн агаарын навигацийн үйлчилгээний мэдээллийн солилцоог шуурхай, оновчтой нэгдсэн нэг болгох систем даяарх мэдээллийн менежмент буюу SWIM концепц нь нисэхийн мэдээлэл солилцоо (AIXM), нислэгийн баримт бичгийн мэдээлэл солилцоо (FIXM), цаг уурын мэдээлэл солилцоо (IWXXM) гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. Систем даяарх мэдээллийн менежмент (SWIM)-ийн хүрээнд агаарын навигацийн үйлчилгээн дэх нисэхийн цаг уурын үйлчилгээг дэмжих зорилгын хүрээнд ОУИНБ ба ДЦУБ-ын хамтарсан ажлын хүрээнд IWXXM 2 хувилбарын ерөнхий бүтцийг гаргасан. Энэхүү ерөнхий бүтцийн дагуу улс орнууд өөрсдийн IWXXM загварт шилжих программаа бичиж, хөгжүүлж байна. БНХАУ-ын Хонгконгийн хувьд Marforce программ дээр үндэслэн IWXXM (TAC to XML) хөрвүүлгийн программаа хөгжүүлж байна.

Сургалтад оролцогчид өөрийн орны нисэхийн цаг уурын үйлчилгээ болон нислэг хөдөлгөөний хамтын ажиллагааны талаар танилцуулж тэдгээрийн давуу болон сул талууд цаашид нисэхийн цаг уурын үйлчилгээг сайжруулахад хийгдэх шаардлагатай ажлуудын талаар хэлэлцүүлэг хийсэн.

Сургалтад оролцогч улс орнуудаас БНЭУ манан прогнолох загварчлал, Япон улс цаг уурын үйлчилгээний сайжруулалт ба нислэг хөдөлгөөний хамтын ажиллагаа,

ОХУ хэт богино хугацааны прогноз, Мьянмар улс, Малайз улс, Монгол улс, Нигери улс, Өмнөд Африк улс, Балба улс зэрэг өөрийн орны нисэхийн цаг уурын үйлчилгээний тухай танилцуулга илтгэл тавьсан.

Манай орны хувьд нисэхийн цаг уурын үйлчилгээ ба нислэг хөдөлгөөний үйлчилгээний хамтын ажиллагаа, цаг уурын хэт богино хугацааны прогнозын загвар, IWXXM-ийн хэрэгжилт зэрэг асуудлын талаар бусад улс орнуудаас туршлага судалж солилцон ур чадвараа ахиулсан үр дүнтэй сургалт болсон.

Олон улсын агаарын навигацийн үйлчилгээний аюулгүй, тогтвортой, үр ашигтай байдлыг хангахад нисэхийн цаг уурын үйлчилгээг сайжруулах ДЦУБ-ын санаачлагаар SIGMET coordination төслийн хүрээнд хийгдэж буй БНХАУ-ын SIGMET платформ болон ОХУ-ын SIGMET платформ-д нэгдэх хүсэлтийг тавьсан. ОХУ-лстай хамтын ажиллагааны дагуу бид ОХУ-ын SIGMET платформ-д нэгдэх хүсэлтийг гаргах боломжтой. Мөн агаарын хөлгийн ажиглалтын мэдээ буюу PIREP мэдээг дамжуулах талаар Япон улсаас зөвлөмж авсан зэрэг бусад улс орнуудаас туршлага судлан цаашдын бодлого, төлөвлөгөөг сайжруулахад маш том түлхэц өгсөн ач холбогдолтой сургалт семинар боллоо.

Тайлан бичсэн:

НЦУТ-ийн ахлах синоптик

инженер

Н.Энхдалай